



ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

СУРГУУЛИЙН НЭР: АШУУИС-ийн Био-Анагаахын сургууль

ХӨТӨЛБӨРИЙН НЭР: Мэдээлэл зүй (эрүүл мэндийн)

ХӨТӨЛБӨРИЙН ИНДЕКС: D061101

ШИНЖЭЭЧ:

Ц.ГАНБАТ

Улаанбаатар хот

2020 ОН

АГУУЛГА

А. Магадлан итгэмжлэлийн үйл явц

Б. Товч мэдээлэл

В. Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлагын дагуу хийсэн шинжээчийн үнэлгээ

1. Хөтөлбөрийн төлөвлөлт

2. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

3. Багшийн үйл ажиллагаа

Г. Шинжээчийн дүгнэлт

А. МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ҮЙЛ ЯВЦ

Уг хөтөлбөр 2018 оны 11 сарын 21 өдөр Б.Сувдаа (МУИС), Ч.Долгоржав (МУБИС), Б.Ундрал (Номч ИТ ХХК) бүрэлдэхүүнтэй шинжээчийн багаар хөндлөнгийн үнэлгээ хийгдэж 2019 оны 4 сарын 17 өдөр Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэгдэж 1 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдсэн. Уг хурлаар хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн 3 шалгуурт зөвлөмж, 1 шалгуурт шаардлага хүргүүлсэн билээ. Бусад шалгууруудыг бүрэн хангасан гэж үзсэн.

Иймд энэ удаагийн магадлан итгэмжлэлийн хөндлөнгийн үнэлгээг мэргэжлийн зөвлөлийн өгсөн 3 зөвлөмж, 1 шаардлагын дагуу үнэлгээ хийсэн болно.

Хөтөлбөрийн нэр /монгол хэлээр/	Хөтөлбөрийн нэр /англи хэлээр/
Мэдээлэл зүй (эрүүл мэндийн) D061101	Health Informatics
Шинжээч томилсон тушаал: БМИҮЗ-ийн Ажлын албаны захирлын 2020 оны 05 дүгээр сарын 29-ны өдрийн А/77 тоот тушаал Шинжээчтэй хийсэн гэрээ: 2020.06.04 №30/2020 Үнэлгээний тайлан: 2020.06.09 Сургууль дээр ажиллах: 2020.06.08	
Шинжээч: 1. Овог нэр: Ц.Ганбат Ажил албан тушаал: Профессор Ажлын газар: ШУТИС, МХТС	
БМИҮЗ-ийн ажлын албаны мэргэжилтэн: Б.Мядагмаа	
Шалгуур шаардлага: БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага”	

Б. ХӨТӨЛБӨРИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Хөтөлбөрийн нэр, индекс	Хөтөлбөрийн багийн ахлагч	Сургалтын хэлбэр	Хугацаа	Кредит
Мэдээлэл зүй D061101	Л.Пүрэвдолгор Ph.D	Үндсэн	4жил	120

В. ХӨТӨЛБӨРИЙН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН ШАЛГУУР, ШААРДЛАГЫН ДАГУУ ХИЙСЭН ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ

ШАЛГУУР 1. ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна

1.1 Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна

Баримт нотолгоо:

- Хөтөлбөр
- Өөрийн үнэлгээний тайлан
- Дүрэм, журам
- Хурлын протоколууд

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

Дүгнэлт:

- Хөтөлбөрийн шинэчлэлтийг ажлын хэсэг байгуулж 2019 оны 9 сарын 27-оос хойш 2020 оны 2 сарын 5 хүртэл их дээд сургуулиудын мэргэжлийн зөвлөхүүдээс санал авч, тэнхмийн хурал, дэд болон сургуулийн хөтөлбөрийн хороогоор хэлэлцүүлсэн байна.
- Хөтөлбөрийг БСШУ-ны сайдын 2014 оны 04 сарын 28-ны өдрийн А/174 тушаалын хавсралтаар батлагдсан “Дээд боловсролын бакалаврын хөтөлбөрт

тавигдах нийтлэг шаардлага”, 2014 оны 03 сарын 13 өдрийн А/78 тоот тушаалаар батлагдсан 061101 индексээр дагуу тэнхимийн багш нар эрүүл мэндийн мэдээлэл зүй хөтөлбөрийг шинэчлэн боловсруулан, сургуулийнхаа хөтөлбөрийн ерөнхий хороогоор хэлэлцүүлж, батлуулжээ. Дээд боловсролын бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагын хангасан.

1.2 Хөтөлбөрийн үзэл баримтлал, зорилго

Хөтөлбөрийн үзэл баримтлал тодорхой; төгсөгчийн эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, хандлага нь мэргэжлийн салбарын хөгжил, зах зээлийн эрэлтэд нийцсэн байна.

Баримт нотолгоо:

- Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан
- Хөтөлбөр
- Эрэлт хэрэгцээний судалгаа

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

Дүгнэлт:

Хөтөлбөрийн зорилго шаардлагын дагуу хангаж байна. Өөрийн үнэлгээний тайлан, сургалтын хөтөлбөрт хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон. Энэ нь мэргэжлийн чиглэл, үндэсний болон олон улсын нийтлэг чадамжид нийцэж байна. Хөтөлбөрийн эрэлт хэрэгцээний судалгааг хийж, хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон байна.

Зөвлөмж

- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн (PLO), хичээлийн суралцахуйн үр дүн (CLO) хоорондын хамаарлыг харуулбал зүйтэй.

1.3 Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга; сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй; сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тогтмол тусган сайжруулдаг байна.

Баримт нотолгоо:

- Мэдээлэл зүй хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой бичиг баримт
- Хичээлүүдийн хөтөлбөр

- Сургалтын төлөвлөгөө
- Эрх зүйн бичиг баримтууд

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

Дүгнэлт:

- Хөтөлбөрийн хичээлүүдийг үзсэний үндсэн дээр 3 чиглэлээр тодорхойлж төлөвлөжээ. Үүнд эрүүл мэндийн, мэдээллийн технологийн, эмнэлгийн үйл ажиллагааны. Эдгээр нь гадаадын эрүүл мэндийн мэдээлэл зүйн сургалт явуулдаг их, дээд сургуулиудтай төсөөтэй, өнөө үед зах зээлд эрэлт хэрэгцээтэй, мэдээллийн технологийн дэвшилтэт технологиудыг эзэмшүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг чиглүүлэхэд үндэс суурь болж байна.
- Суралцагсдын гол дүнгээс хамаарч төгсөлтийн ажлыг мэргэжлийн шалгалт, дипломын ажил гэсэн 2 сонголттойгоор хийжээ.
- Нийт 67 хичээлийн хөтөлбөр сургалтын хөтөлбөрт чиглэгдсэн байсан бөгөөд хичээлийн агуулга, зорилго, хичээл олж авах мэдлэг, ур чадвар, хичээлийн төлөвлөгөөг гаргасан.

Зөвлөмж

- Мэргэжлийн суурь, мэргэжлийн зарим хичээлийн агуулгыг эрүүл мэндийн чиглэлийн үйлчилгээг үзүүлэх системийг зохиомжлох, хөгжүүлэхэд чиглүүлэх шаардлагатай
- Дадлагын цагийг нэмэгдүүлэх

ШАЛГУУР 3. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

3.1 Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Баримт нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан, сургалтын хөтөлбөр дээр тусгагдсан байна
- Дэд хороо, сургуулийн хөтөлбөрийн хороо, тэнхмийн хурлын протоколууд

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

Дүгнэлт:

- Хөтөлбөрийн шинэчлэхийн тулд 2019 оны 9 сарын 27-оос хойш 2020 оны 2 сарын 5 хооронд сонирхогч талууд болох их дээд сургуулиудын мэргэжлийн зөвлөхүүд, төгсөгч, ажил олгогч нартай уулзаж санал хүсэлтийг авсан байна.
- Эрүүл Мэндийн Сайдын 2020 оны 1-р сарын 13-ны өдрийн А/13 дугаар тушаалаар Эрүүл мэндийн салбарын мэдээлэл технологийн бодлого, мэргэжлийн зөвлөх чиг үүрэг бүхий Эрүүл Мэндийн Яамны орон тооны бус мэргэжлийн салбар зөвлөл 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан ба уг зөвлөлд тэнхмийн 2 багш орж ажиллаж байна.

3.2 Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Үзүүлэлт нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Сургалтын хөтөлбөр
- Сургуулийн жилийн тайлан
- Ажил олгогчдын ажлын байрны судалгаа, зар
- Элсэгчдэд зориулсан гарын авлага
- Мэргэжил сурталчлах өдөрлөгийн тайлан

3.3 Төгсөлтийн дараах бодлого

Хөтөлбөр нь төгсөгчидтэйгээ байнгын эргэх холбоотой, тэдний мэргэжлийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулж, төгсөгчид нь суралцаж буй суралцагчдад мэргэжлийн чиглэлээр ажиллахад нь зөвлөн тусладаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Үзүүлэлт нотолгоо:

- Төгсөгчдийн карьерын өсөлтийн судалгаа
- Үргэлжлүүлэн суралцагчдын хувь хэмжээ
- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулах бодлого, төлөвлөгөө, хамрагдсан байдал
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны тогтмолжсон байдал

Дүгнэлт

- Төгсөлтийн дараах бодлого хэрэгжүүлдэг, үйл ажиллагаа явуулдаг. Төгсөгчдийн карьерын судалгааг хийхэд цөөнгүй төгсөгчид томоохон эрүүл мэндийн салбар төв, эмнэлгүүдийн мэдээллийн технологийн албаны дарга, МТ-ийн мэргэжилтэн, сүлжээний инженер, удирдлага, тоног төхөөрөмжийн инженер хийж байна.
- Ажил олгогчдоос мэргэжилтний ажлын байрны шаардлагатай хэр нийцэж байгаа талаар судалгаа авахад 80,6% нь сайн, 18,2% нь дунд, 1,2% нь муу гэсэн үнэлгээ өгсөн байна.
- АШУҮИС-д эрүүл мэндийн МТ-ийн чиглэлээр давтан сургалт одоогоор байхгүй, цаашид төлөвлөж байна. Төгсөгчдийн холбооны үйл ажиллагаа сайн байна.

3.4 Олон улсын харилцаа, хамтын ажиллагаа

Олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагуудтай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Үзүүлэлт нотолгоо:

- Хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн гэрээ, тайлан
- Сургуулийн жилийн тайлан
- Эрдэм шинжилгээний бичиг, хурлын эмхэтгэл

Дүгнэлт

- Тэнхмийн сургалт, семинар хийж байна.
- Мэргэжлийн байгууллагуудтай холбоо тогтоож хамтарч ажиллах дээр судалгаа хийж ахиц гарч байна. ШУТС-д төслийн санал илгээж шалгарсан. Гадаадын их дээд сургуультай хамтрах талаар хэлэлцэгдэж байна.

3.5 Дотоод хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нь мэргэжлийн холбоод, үйлдвэр, үйлчилгээний байгууллагууд, ажил олгогч эздийн холбоо, төрийн болон ТББ-уудтай хамтран ажилладаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Үзүүлэлт нотолгоо:

- Хамтран ажиллах гэрээ, хэлцэл, ажлын үр дүн
- Хэрэгжүүлж буй ажлуудын тайлан, дүгнэлт
- Хамтын ажиллагааны арга, туршлага
- Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо үр дүн /багш, суралцагчдын зүгээс/

Дүгнэлт

- Дотоод хамтын ажиллагаа сайн болох нь харагдаж байна. Тухайлбал 2004 оноос 1, 2-р шатлалын эмнэлгүүдтэй хамтран “Сүлжээний техник”, “Компьютерт суурилсан эмнэлгийн тоног төхөөрөмж” сэдэвт зуны дадлагыг жил бүр хийдэг. Мөн Монгол-Японы сургалтын эмнэлэг дээр дадлага хийх бүрэн боломжтой болсон байна.
- Мөн ижил төстэй хөтөлбөрөөр сургалт явуулдаг дотоодын их дээд сургуулиудтай хамтын ажиллагааны гэрээтэй, жил бүр эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах зэрэг идэвхтэй ажиллаж байна. Мөн багш, ажилчдын нийгмийн хангамжийг сайжруулах зорилгоор Капитрон банк, “Эрхэс” Их сургуулийн нэгдсэн эмнэлэг, Төв аймгийн Баян чандмань суман дахь сувиллын газар зэрэгтэй хамтын ажиллагааны гэрээтэй ажиллаж байна.

3.6 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Үзүүлэлт нотолгоо:

- Төсөв, санхүүгийн бие даасан байдлын хөгжил
- Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв
- Төр хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалт
- Төсвийн уламжлалт бус эх үүсвэр, бүрдүүлэлт, хуваарилалт, санхүүжилт

Дүгнэлт

- 2017 оны байдлаар БАС нь АШУҮИС-ийн нийт орлогын 23% болох 5.9 сая төгрөгийг 58726 төгрөгөөс бусдыг нь оюутны төлбөрөөр оруулсан байна. Нэг

оюутны төлбөр дунджаар 2.9 сая төгрөг, үүний 63% нь цалинд 2.5% нь бичиг хэрэг, шуудан холбоонд, 12.7 % хичээл практик, ном хэвлэлд, 4% орчим нь лабораторийн тоног төхөөрөмж гэх зэргээр зарцуулагдаж байна.

Шалгуур 5. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

5.1. Багшийн сонгон шалгаруулалт, албан тушаал, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлого: тушаал, урамшууллын бодлого
- Сонгон шалгаруулалт, хөгжүүлэлт, төлөвлөлт, хэрэгжилт
- АШУҮИС-ийн захирлын тушаал
- Сургалтын албаны тайлан
- Шагнагдсан багш нарын шагналууд, гэрчилгээ, батламж

Дүгнэлт

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч багийн багш нарын 45.4% докторын зэрэгтэй.
- Багшийн албан тушаалын зэрэглэл өөрчлөхдөө 3 жил тутам аттестатчлал хийгддэг. Багш өөрөө хүсвэл 3 жилийн дотор саналаараа хөндлөнгийн үнэлгээ хийлгэж болдог онцлогтой.
- Дадлагажигч багшийн хувьд БХТ болон СБЗГ-ын бодлогоор хөндлөнгийн үнэлгээг 3 жил дараалан хийлгэдэг.
- БХТ-өөс сурган, заах арга зүйн сургалт явуулж багшлах эрх олгодог.
- Их сургуулийн захирлын 2016 он А/109 тушаалаар эрдэм шинжилгээний ажилд шаталсан урамшууллын тогтолцоо бий болсон (импакт өндөртэй сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн урамшуулал, докторын сургалтын төлбөрийн хөнгөлөлт).
- Хөдөлмөрийн гэрээний биелэлтээр сургуулийн шилдэг багш, тэнхимийг шалгаруулах, урамшуулах тогтолцоотой.

- Мэргэжлийн багш дутагдалтай учраас багшийн ачаалал өндөр байгаа тул багшийн эрдэм, судлалын ажилд сөргөөр нөлөөлж болзошгүй. Төгсөгчдөөсөө багшаар авахаар төлөвлөж байна

5.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Үзүүлэлт нотолгоо:

- Багшийн хөгжлийн хөтөлбөр, хэрэгжилт, дүн шинжилгээ
- Өөрийн үнэлгээний тайлан
- Сургалтын хөтөлбөр

Дүгнэлт

- Багш хөгжлийн төв (БХТ) 2014 оноос хойш тогтмол үйл ажиллагаатай, хөтөлбөртэй
- Багшийн заах арга зүйг сайжруулах олон төрлийн сургалт явуулдаг
- Урт болоод богино хугацааны мэргэжил, ур чадвар дээшлүүлэх дотоодын сургалтад хөтөлбөр хэрэгжүүлэгч профессорын багаас 49 багш, гадаадад урт богино хугацаанд туршлага судлахаар 14 багш тус тус хамрагдсан байна (давхардсан тоогоор). Гадаадад урт хугацааны сургалтад 3 багш хамрагдсан.
- Профессорын багийн багш нар дотоод нөөц бололцоондоо тулгуурлан мэргэжлийн баг дотроо сургалт явуулдаг.
- Мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээл заадаг багш нарыг тухайн чиглэлээр түлхүү сургалтад хамруулах

5.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Үзүүлэлт нотолгоо:

- Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, патентийн тоо
- Захиалгат төсөл, гэрээт ажилд оролцсон байдал
- Үндэсний болон олон улсын нэр хүндтэй хэвлэлд нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн байдал

Дүгнэлт

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч багийн эрдэм шинжилгээ, судалгааны ажил, чанар тогтмолжиж байгаа бөгөөд Цөм лаборатори байгуулсан нь тоног төхөөрөмжийг судлах, хичээлд ашиглах бааз болгож ашиглах, багшийн судалгааны ажилд түлхэц болсон байна.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч болон оролцогч багш нарын захиалгат төсөл болон гэрээт ажлууд дахь оролцоо жил ирэх бүр нэмэгдэн, тайлангийн хугацаанд хөтөлбөр хэрэгжүүлэгч профессорын багийн гишүүдийн удирдсан болон оролцоот төсөлт ажил 3 хэрэгжсэн байна.
- Анагаахын физик, мэдээлэл зүйн профессорын багийн бүтээл:
 - Нэг сэдэвт бүтээл 3
 - Сурах бичиг 13
 - Гарын авлаг 31
 - Ард иргэдэд зөвлөлгөө 13
 - Өгүүлэл (Гадаад 17, дотоод 59) 76
 - Илтгэл (Гадаад 6, дотоод 21) 27
 - Зохиогчийн эрх 8
- Сургуулийн дэргэдэх MedIT гарааны компанитай
- Олон улсын болон дотоодын хуралд судалгааны ажлаа илтгэх, IF бүхий сэтгүүлд хэвлүүлэх ажил тасралтгүй хийгддэг болох нь харагдаж байна. АШУУИС нь IF өндөртэй сэтгүүлд нийтлүүлсэн бүтээлийн урамшууллын тогтолцоог хэрэгжүүлж байгаа нь цаашид бүтээлийн тоо нэмэгдэх хандлагатай.

5.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Үзүүлэлт нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Багшийн хөндлөнгийн үнэлгээ /Аттестатчлал, эрэмблэлт, чансаа тогтоолт/
- Сургалтад ашиглаж буй сургах/заах аргын үр дүн, үр нөлөөний судалгаа
- Протоколууд
- Багшийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх 14 журам

Дүгнэлт

- Хөдөлмөрийн гэрээгээр багш нарыг жил бүр дүгнэж урамшуулдаг.
- Багшийн үйл ажиллагаа, заах арга зүй болон хичээлийн үр дүн, хэрэгжилтийг оюутнаар үнэлүүлж, үр дүнг тооцдог.
- Профессорын багийн ахлагч нь хөтөлбөрийн хэрэгжилтэд шууд хяналт тавьдаг бол СБЗГ багшийн ёс зүйг үнэлнэ.
- “Профессоруудын зөвлөх баг” нь залуу багш нарын хичээлд сууж, зөвлөх, багш нарын заах арга, сургалтын технологийг сайжруулах ажил хийдэг.

ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ:

- Сургалтын хөтөлбөрийг мэргэжилтнүүдээс зөвлөгөө авч тэнхмийн хурлаар оруулж, дэд хороогоор хэлэлцүүлсэн байна
- Хөтөлбөрийн зорилгыг сургуулийн зорилгот нийцүүлэн шинэчлэсэн
- Багшийн чадвахыг дээшлүүлэхэд ахиц гарсан
- Сургалтын төлөвлөгөөг шинэчлэсэн
- Хөтөлбөр шаардлагыг бүрэн хангасан тул магадлан итгэмжлэх хүсэлт гаргаж байна

ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ

№	Шалгуур	Үнэлгээ	Тайлбар
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	Бүрэн хангасан	1.1 Бүрэн хангасан 1.2 Бүрэн хангасан 1.3 Бүрэн хангасан
2	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	Бүрэн хангасан	3.1 Бүрэн хангасан 3.2 Бүрэн хангасан 3.3 Бүрэн хангасан 3.4 Бүрэн хангасан 3.5 Бүрэн хангасан 3.6 Бүрэн хангасан
3	Багшийн үйл ажиллагаа	Бүрэн хангасан	5.1 Бүрэн хангасан 5.2 Бүрэн хангасан 5.3 Бүрэн хангасан 5.4 Бүрэн хангасан
НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ		Бүрэн хангасан	

Баримт материал, хөтөлбөр, төлөвлөгөө, тайлан, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээч АШУҮИС-ийн Био Анагаахын сургуулийн “Мэдээлэл зүй (эрүүл мэндийн)” бакалаврын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагад нийцэж байгаа тул ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН гэж дүгнэж байна.

Шинжээчийн дүгнэлтийг Мэдээлэл, харилцаа холбооны технологийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээч:

Ц.Ганбат